

НИЙСЛЭЛИЙН ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ТӨВ-СОНГИНОХАЙРХАН САЛБАРТ 2018 ОНЫ 05 ДУГААР
САРЫН 06-НЫ ӨДӨР “ТАРХИНЫ ЦУС ХАРВАЛТ, АРТЕРИЙН ГИПЕРТЕНЗИ, МУХАР ОЛГОЙН
ЦОЧМОГ ҮРЭВСЭЛ”-ИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛЬЯ СЭДЭВТ ҮЗҮҮЛЭХ СУРГАЛТ,
ХЭЛЭЛЦҮҮЛЭГ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БЯАГУУЛАГДЛАА.

Хэлэлцүүлэгт чанарын албаны дарга Д.Мөнхцэцэг, чанарын менежер М.Наранбайгаль, СХС-ын эрхлэгчийг З.Энхцэцэг, 2-р ээлжийн зохицуулагч Б.Цэцэгчулуун, 3-р ээлжийн зохицуулагч Т.Алдартүшиг, их эмч Г.Алтанчулуун, М.Энхтуяа, Б.Батбулган, Э.Эрдэнэцэцэг болон 2, 3-р ээлжийн их эмч, дагалдан эмч нар идэвхтэй сайн оролцсон.

Нийт оролцсон хүний тоо- 31.

1. Хэлэлцүүлэг хөтөлбөрийг танилцуулж 2-р ээлжийн зохицуулагч Б.Цэцэгчулуун удирдан зохион байгуулсан.



2. “Артерийн гипертензи”, “Тархины цус харвалт”-ын үед үзүүлэх тусламж үйлчилгээ, гардан үйлдлийг бодит тохиолдол дээр суурилсан алдаатай болон эмнэлзүйн удирдамжийн дагуу дуудлага авах, дуудлагыг их эмчид шилжүүлэх ажилбараас эхлээд бодит үзлэг, асуумж, өвчний түүх, амьдралын түүх, газар дээрхи болон эмнэлэг хүртэлх эмнэлгийн тусламж үйлчилгээг бодитоор 3-р ээлжийн их эмч Г.Алтанчулуун, Б.Батбулган, Э.Эрдэнэцэцэг, их эмч нар хамтран хийж үзүүлсэн.







3. “Мухар олгойн цочмог үрэвсэл”-ийн үед үзүүлэх гардан үйлдлийг эмнэлзүйн удирдамж, стандартын дагуу бодит үзлэг, асуумж, өвчний түүх, амьдралын түүх зэрэг оношийн үндэслэлтэй, оношлох симптомуудыг бодитоор үзүүлж, ялган оношлогоог 2-р ээлжийн их эмч М.Энхтуяа, их эмч нар хамтран хийж үзүүлсэн.



4. Онолын мэдээллийг


- ✓ “Артерийн гипертензийн эмнэлзүйн удирдамж, сүүлийн үеийн чиг хандлага” онолын мэдээллийг их эмч Г.Алтанчулуун
- ✓ “Тархины цус харвалтын эмнэлзүйн удирдамж, сүүлийн үеийн чиг хандлага” онолын мэдээллийг их эмч Э.Эрдэнэцэцэг
- ✓ “Мухар олгойн цочмог үрэвслийн эмнэлзүйн удирдамж, сүүлийн үеийн чиг хандлага, хэвлийн бусад өвдөлтөөс ялгах” онолын мэдээллийг их эмч М.Энхтуяа нар тус тус өгсөн.



5. Шүүмж:

- ✓ Бодит дээрхи тохиолдол дээр суурилсан дуудлагын хуудас бүрийн бичилтэнд, нийт 3 дуудлагын хуудсанд шүүмжийг 2-р ээлжийн зохицуулагч Б.Цэцэгчулуун хийсэн.

- ✓ Бодит тохиолдол дээр суурилсан “Мухар олгойн цочмог үрэвсэл” оноштой дуудлагын хуудсанд шүүмжийг 2-р ээлжийн зохицуулагч Б.Чандалдулам хийсэн.



6. 15 минутын завсарлага
7. Хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт “Артерийн гипертензи”, “Тархины цус харвалт”, “Мухар олгойн цочмог үрэвсэл” сэдвээр нийт эмч нарын дунд ярилцлага хэлэлцүүлгийг хийсэн. үргэлжилсэн хугацаа 50 минут. зураг:
8. Хэлэлцүүлэг, үзүүлэх сургалт, шүүмжээс санал солилцож, чөлөөт ярилцлага 45 минут хийж үүнээс зөвлөмжийг нэгтгэж гаргав.
9. Хэлэлцүүлэг, үзүүлэх сургалтаас гарсан зөвлөмж, дүгнэлтийг чанарын албаны дарга Д.Мөнхцэцэг хийж, хэлэлцүүлгийн үйл ажиллагааг амжилттай зохион байгуулан явуулсанд талархаж, хааж үг хэлсэн.
10. Хэлэлцүүлгээс гарсан зөвлөмж:
 - a) Эмч нар онолын мэдлэгээ байнга сайжруулж байх
 - b) Онолын мэдлэгээс гадна харьцаа хандлагаа сайжруулах, биеийн болон үгийн хэлэмж илэрхийлэл дээр анхаарч ажиллах, сэтгэл ханамжтай үйлчлэх
 - c) “Артерийн гипертензи”, “Тархины харвалт”, “Мухар олгойн цочмог үрэвсэл” дуудлагын хуудас шалгах чек лист гаргаж, загвар болгох
 - d) Хэлэлцүүлэгт хийсэн онолын мэдээллээ бусад салбарын эмч нарт мэдээлж, зөвлөгөө өгч хамтран ажиллах

ТАЙЛАН БИЧСЭН:

ХҮҮХДИЙН МЭРГЭЖИЛТЭН

З.ЭНХЦЭЦЭГ